

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Зах зээлийн судалгаа – нэгдүгээр бүлэг
МОНГОЛ УЛС ДАХЬ БОРДОО,
УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИСЫН
ХЭРЭГЦЭЭ БА ХЭРЭГЛЭГЧДИЙН ХАНДЛАГА



Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл
Др. Проф. Г. Гантулга
Др. Д. Ундармаа
2016 оны 10-11 сар



Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Зах зээлийн судалгаа – нэгдүгээр бүлэг
Монгол улс дахь бордоо, ургамал
хамгааллын бодисын хэрэгцээ ба
хэрэглэгчдийн хандлага



Герман-Монголын хамтын ажиллагааны

Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Засгийн газрын Iха байр, 501

Энхтайваны өргөн чөлөө 16А

13381 Улаанбаатар

Монгол улс

Хянан тохиолдуулсан/ эмхэтгэсэн:

Др. А. Катер

Э. Хатантуул

ГАРЧИГ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	5
1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	5
2. АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ХӨРС, ШИМТ БОДИСЫН ХАНГАМЖИЙН ТАЛААРХИ ОЙЛГОЛТ.....	6
3. АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН БОРДООНЫ ХЭРЭГЛЭЭ	7
4. УРГАМЛЫН ӨВЧИН, ХОРТОН ШАВЬЖ, ХОГ УРГАМЛЫН ТАЛААРХ ТАРИАЛАНЧДЫН МЭДЛЭГ.....	7
5. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ, ХАНДЛАГА.....	8
6. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС, БОРДООНЫ ОЛДОЦ ХУДАЛДАН АВАЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ.....	9
7. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС ШҮРШИХ, БОРДОО ЦАЦАХ ТЕХНИКИЙН ХАНГАМЖ.....	9
8. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС БОЛОН БОРДООНЫ СОНГОЛТ.....	10
9. ДҮГНЭЛТ БА ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ.....	11
10.ХАВСРАЛТ	14

Хавсралт 1: Зураг/ график

Хавсралт 2: Ургамал хамгааллын бодис/ бордооны асуулгын хуудас

Хавсралт 3: Монгол улсад 2016 онд газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох химийн бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээ

Хавсралт 4: Монгол улсад 2016 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ

Хавсралт 5: Монгол улсад 2016 онд ашиглаж болох ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, хэрэглэх хэмжээ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ХААИС-ийн профессорын баг Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий аймгийн нутагт байрлах газар тариалангийн үйл ажиллагаа тогтвортой эрхэлж буй нийт 42 аж ахуйн нэгжүүдээс бордоо болон ургамал хамгааллын бодисын хэрэгцээ ба хэрэглэгчдийн хандлагын талаар түүвэр судалгаа авсан болно. Тус судалгааны ажлын хүрээнд эдгээр аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, тэдгээрийн газар тариалангийн үйлдвэрлэлийн үндсэн мэдээлэл цуглуулахын зэрэгцээ хөрс хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх болон ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж буй ажлын үр дүнгийн талаар санал асуулга явуулах, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар тэдний санал бодлыг сонсож, цуглуулсан мэдээлэлд судалгааны арга зүйн дагуу тоон боловсруулалт, дүн шинжилгээ хийж ажилласан ба үр дүнг энэхүү тайланд тусгасан болно.

1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн туршлага: Тус судалгаанд Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий аймгийн нутгуудад байрлах нийт 42 компани, аж ахуй нэгж хамрагдсан бөгөөд эдгээрийг газар тариалангийн бизнес эрхэлсэн туршлагаар нь авч үзвэл 25 компани нь 15 -аас дээш жил, 6 компани нь 10-аас дээш, 8 компани нь 5-10 жил, 3 компани 5 жил хүртлэх хугацаанд энэхүү бизнесийг эрхэлж байгаа бөгөөд эдгээрээс 60 орчим хувь нь газар тариалангийн үйлдвэрлэл харьцангуй тогтвортой эрхэлсэн, туршлагатай аж ахуйн нэгж байв.

Аж ахуйн нэгжүүдийн талбайн хэмжээ: Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн 41% нь 1000-5000 га, 26% нь 100-1000 га, 11% нь 50-100 га, мөн 11% нь 10-50 га, мөн 11% нь 5 га хүртлэх эргэлтийн талбайд төрөл бүрийн таримал тариалж байгаа ба ихэнх аж ахуйн нэгж 1000 хүртэл түүнээс дээш талбайд үйлдвэрлэл явуулж байна.

Аж ахуйн нэгжүүдийн тариалалт: Судалгаанд хамрагдсан нийт 42 компаниас 21 аж ахуй нэгж үр тарианы үйлдвэрлэл явуулж, 200-4000 га талбайд тариалалт хийж байгаагаас Сэлэнгэ аймгийн Хушаат сум Ньюкроп ХХК /60 га/, Дархан-уул аймгийн Хонгор сум дахь Өглөгчийн хэрэм/100 га/ зэрэг аж ахуйн нэгжүүд усалгаатай нөхцөлд улаан бүүдай тариалж байна. Үр тарианы үйлдвэрлэл эрхэлж буй нийт аж ахуйн нэгжүүд 2015-2016 оны байдлаар нэгж талбайгаас 0,7-2,4 тонн хүртлэх ургац хурааж байсан байна.

Судалгаанд хамрагдсан компаниуд нь улаан бүүдайнаас гадна рапс, гурвалжин бүүдай, тэжээлийн олон наст ургамал зэргийг таримлын сэлгээнд оруулан тариалдаг бөгөөд ихэвчлэн дагнан их хэмжээгээр тариалсанаар авч үзвэл рапсыг 13 аж ахуй, төмсийг 13 аж ахуй, хүнсний ногоог 30 аж ахуй нэгж дагнан болон хосолсон хэлбэрээр тариалан бизнес эрхэлж байна. Дээрх аж ахуй нэгжүүд нь рапсыг 34-2000 га талбайд тариалж, 2015-2016 онуудад 0,4-1,2 тн/га ургац хурааж байсан байна. Харин төмсийг 0,5-100 га талбайд тариалан 4-28 тн/га ургац мөн жилүүдэд хурааж авсан байна.

Хүнсний ногоо үйлдвэрлэх бизнесийг мөн дангаар болон хавсарга бизнес байдлаар эрхэлж байгаа 30 аж ахуй нэгж байгаа бөгөөд эдгээр нь лууван, манжин, байцаа, сонгино, хэмх зэрэг ногоог тариалж байна. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид нь 0,1-30 га талбайд янз бүрийн ногоог тариалж байна. Бусад тарималуудтай харьцуулахад хүнсний ногоог илүү усалгаатай талбайд тариалж байна.

2. АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ХӨРС, ШИМТ БОДИСЫН ХАНГАМЖИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Судалгаанд оролцогч компаниудаас 82% нь өөрийн талбайн хөрсний хэв шинжийг мэддэг гэж хариулсан бол 18% нь ямар нэгэн мэдлэг байхгүй гэж хариулсан байна /Зураг 1/. Харин тухайн аж ахуй нэгжийн талбайн хөрсний шим тэжээлийн бодисын хангамжийн талаарх асуултанд ихэнх оролцогчид “дунд зэрэг” мэднэ гэж хариулсан бол 4 аж ахуйн нэгж “сайн” нь, 5 аж ахуй нэгж “мүү” гэж хариулж байлаа. Эндээс үзэхэд ихэнх аж ахуйн нэгж талбайнхаа хөрсний хэв шинжийн талаар маш муу ойлголттой байгаа нь харагдаж байна. Мөн талбайн хөрсний шим тэжээлийн бодисын хангамжийн талаар мэдлэг дулимаг байна. Аж ахуй нэгжүүдийн тариалангийн талбайн хөрс тариалан эрхлэхэд хэр тохиромжтой вэ гэж асуухад 35 аж ахуй нэгж буюу 83% нь тохиромжтой гэсэн бол 4 нь дунд зэрэг, 3 нь хариулаагүй байна.

Тариаланчид хөрсний дээж авах, хөрс шинжилгээнд бэлтгэх, хөрсний үржил шимийг хамгаалах талаарх мэдлэг, мэдээлэл ямар байгаа талаар авсан судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн 82% нь хөрсөө шинжлүүлдэг гэж хариулсан байна /Зураг-2/. Хөрсний шинжилгээг ямар давтамжтайгаар хийлгэж байгааг судалж 16 аж ахуй нэгж 5-10 жил, 12 аж ахуй нэгж 3 жил тутам, жил бүр 5, огт хийлгэдэггүй 5 аж ахуй нэгж байв /Зураг 3/. Ихэнх аж ахуй нэгжүүд хөрсний шинжилгээг Дархан-Уул аймаг дахь УГТЭШХ-ээр хийлгэдэг байна /Зураг 4/.

Мөн түүнчлэн хөрсний дээж авах сургалтанд хамрагддаг эсэх талаар судлахад судалгаанд оролцогсодын 56% нь ямар нэг байдлаар зохих сургалтанд хамрагдсан байна /Зураг 5/. Дийлэнх аж ахуй нэгжүүд хөрсний шинжилгээгээр азот, кали, фосфор үндсэн элементүүдээс гадна хөрсний рН, ялзмагийн агууламжийг тодорхойлуулдаг байна. /Зураг 6/.

Энэ нь аж ахуйн нэгжүүд тариалан эрхэлж буй талбайнхаа хөрсний үржил, шимд ямар нэгэн хэмжээгээр сүүлийн жилүүдэд анхаарал хандуулдаг болсныг харуулж байгаа боловч хөрсний шим тэжээлийн бодисын хангамж ямар төвшинд байгааг тэр бүр мэдэхгүй ямар нэгэн арга хэмжээ авахгүй байгааг илтгэж байна. Судалгаанаас үзэхэд бордоо хэрэглэхийн өмнө хөрсөө шинжилгээнд өгч, гарсан үр дүн дээр нь үндэслэн бордоо хэрэглэдэг аж ахуй нэгж нэг ч алга байв. Судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүд орон нутгийн ХАА-н газрын албан шаардлагаар хөрсөө шинжилгээнд өгдөг. Бодит байдал дээрээ тариаланчид хөрсний шинжилгээний үнэ, цэнэ, ач тусыг ойлгодоггүйтэй холбоотой юм. Албан шаардлагаар хөрсөө шинжлүүлдэг учраас хөрсний шинжилгээний үр дүнг хэрэглэддэггүй гэсэн дүгнэлт хийж болхоор байна.

Харин хөрсний үржил шимийг хамгаалах талаар асуухад ихэнх нь дундаас, маш сайн мэдлэгтэй гэж хариулт өгснөөс үзэхэд тариаланчид хөрсний үржил шимийг хамгаалж байж газар тариалангийн үйлдвэрлэлээс өндөр ашиг хүртэх боломжтой гэдгийг сайн ойлгож байна гэж дүгнэхэд хүргэлээ. /Зураг 7/.

3. АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН БОРДООНЫ ХЭРЭГЛЭЭ

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдээс 82% нь бордоо худалдан авч хэрэглэж байгаа бөгөөд жилд ашиглаж буй бордооны хэмжээ тариалж байгаа талбай, хөрөнгө мөнгөний боломжоос хамаарч өөр байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 31 нь буюу 73% нь жил бүр янз бүрийн хэмжээгээр бордоо ашиглаж байна. /Зураг 8, 9/. Тариаланчид, органик бордоог төмс, хүнсний ногооны талбайд түлхүү ашигладаж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан үр тарианы аж ахуй эрхэлж буй нийт 21 аж ахуйн нэгжийн 8 нь буюу 38 хувь нь органик бордоо хэрэглэдэг байна /Зураг 10/. Эрдэс бордооны хэрэглээ, түүнийг хэрэглэх арга, технологийн талаарх тариаланчдийн мэдлэгтэй холбоотой судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдийн 36 нь буюу ихэнх аж ахуйн нэгж ямар нэгэн хэмжээгээр эрдэс бордоо хэрэглэдэг гэж хариулсан бөгөөд эрдэс бордоог буудай, хүнсний ногооны талбайд илүү хэрэглэж байна /Зураг 11/.

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн 24 нь буюу 57% нь эрдэс бордоог тариалалттай хамт, 21 нь буюу 42% нь ургамал ургалтын хугацаанд давхардуулан хэрэглэдэг гэж хариулсан нь эрдэс, органик бордоог ургамал ургалтын хугацаанд болон тарилттай зэрэгцүүлэн өргөн хэрэглэдэг болохыг харуулж байна /Зураг 12/.

4. УРГАМЛЫН ӨВЧИН, ХОРТОН ШАВЬЖ, ХОГ УРГАМЛЫН ТАЛААРХ ТАРИАЛАНЧДЫН МЭДЛЭГ

Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн хувьд хамгийн их тулгамдсан асуудал нь тариалсан үр тарианы талбайд хог ургамал ургах /30-41%/, хортон мэрэгчид /11-30%/ тархах явдал байгаа бол, төмс, хүнсний ногооны талбайд хөнөөлт шавьж /13-30%/, хог ургамлын тархалт /30-33%/, ургамлын өвчин /21%/, тосны таримлын талбайд хөнөөлт шавьж, хог ургамал, жимс, жимсгэний талбайд хөнөөлт шавьж, луувангийн талбайд хог ургамал давамгайлан түс түс асуудал болж байна /Зураг 13/.

Аж ахуй нэгжүүдийн хувьд тулгардаг нийтлэг асуудал бол үр тариа, төмс, хүнсний ногооны талбайд хог ургамал ургаж тархах явдал юм. Түүнчлэн хог ургамлын тархалтаас гадна хөнөөлт шавьж маш ихээр илэрдэг нь судалгаанаас харагдаж байна./Зураг 14/.

Аж ахуй нэгжүүд хөнөөлт организмтой холбоотой асуудлаар хаанаас зөвлөгөө авдаг талаар тандан судлахад судалгаанд оролцогчдын 17 нь УХЭШХ-ээс, 15 нь пестицид борлуулагчаас 9 нь хөрш тариаланчаас гэж давхардсан тоогоор хариулсан байна. Харин пестицидийн зохистой хэрэглээний сургалтанд хамрагдсан эсэх талаар судалгаа явуулахад

18 аж ахуй нэгж олон удаа хамрагдсан байхад 14 нь огт үгүй, 10 нь хааяа хамрагддаг байна. Энэ нь тариаланчид ургамал хамгааллын асуудлыг ойлгох түвшинд байгааг харуулж байна.

5. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ, ХАНДЛАГА

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн 33 (78.5%) нь гербицид, 18 (42.8%) нь фунгицид 16 (38%) инсектицид, 10 (23%) нь родентицидийг тогтмол хэрэглэж байна /Зураг 15/.

Судалгаа явуулсан нийт 42 аж ахуй нэгжээс 7 (16.6%) аж ахуй нэгж ямар ч төрлийн пестицидийг хэрэглэддэггүй гэж хариулсан байна. Аж ахуйн нэгжүүдийн пестицид хэрэглэсэн түршлага, түлгамдаж буй асуудлын талаар авсан судалгааны үр дүнгээс үзэхэд пестицид хэрэглэдэг аж ахуй нэгжүүдийн 15(35.7%), сүүлийн 5 жил, 13 (30.9%) нь 10-аас дээш жил, 7(16.6%) нь 5-10 жилийн туршид хэрэглэж байна /Зураг 16/.

Эдгээр үр дүнгээс үзэхэд сүүлийн жилүүдэд хөнөөлт организмын гаралт, тархалт болон хөнөөл ихэссэн үүнтэй уялдаатайгаар пестицидийн хэрэглээ ихсэж байгаа хандлага ажиглагдаж байна. Мөн үр тарианы бүх компаниуд тариалтын өмнө үрээ заавал химийн фунгицидээр ариутгаж тариалдаг, хог ургамлын эсрэг заавал гербицид хэрэглэж заншсан нь сайшаалтай. Төмс, хүнсний ногооны талбайд хөнөөлт шавьж их гардаг учраас инсектицид голчлон сонгож хэрэглэдэг байна.

Тариаланчид пестицидийн хэрэглээ, түн хэмжээг тохируулах мэдээллийг худалдан авч байгаа пестицидийн шошгон дээрх мэдээллээс авдаг гэж 22 аж ахуй нэгж буюу 62.8%, борлуулагчаас авдаг гэж 19 аж ахуй нэгж буюу 54.2%, гарын авлага, зөвлөмжөөс авдаг гэж 15 аж ахуй нэгж буюу 42.8%, сургалт, семинараас гэж 13 аж ахуй нэгж буюу 37.1% авдаг гэсэн бол өөрөө тааж хэрэглэдэг гэж 9 аж ахуй нэгж буюу 25.7% нь хариулсан байна /Зураг 17/. Дээрхээс харахад манай тариаланчид пестицидийг зориулалтын дагуу, түн хэмжээгээр нь тохирсон хугацаанд хэрэглэхийг хичээж ажилладаг болохыг илтгэж байна.

Ургамал хамгааллын бодисын хэрэглээний талаарх судалгааны дүнгээс үзэхэд аж ахуйн нэгжүүд нь луувангийн талбайд хог ургамалтай тэмцэхэд Гезагард гербицидийг хамгийн их, буудайн өнжөөсөн талбайд Раундап гербицидийг, хүнсний ногооны талбайд хөнөөлт шавьжийн эсрэг Децис, Карате инсектицидийг тус тус хамгийн их хэрэглэж байна.

Буудай тариалагчид нь тарихын өмнө үрээ Тебу-60 хэмээх фунгицидээр ариутгадаг тул ургамал ургалтын хугацаанд мөөгөнцөрийн өвчин гарах эрсдэл буурсан, хянах боломжтой байгааг илтгэж байна. Харин төмсний аж ахуй эрхлэгчдийн хувьд мөн төмсийг ариутгаж тарьдаг ч гэсэн мөөгөнцөр, бактери, вирусын өвчний гаралт, тархалт ургамал ургалтын хугацаанд буурахгүй байна гэснийг зориуд дурьдаж байна. Тосны таримлын хувьд тохиромжтой гербицид яах аргагүй шаардлагатай байна. Одоогийн байдлаар Монгол улсад рапсын талбайд хэрэглэх гербицид алга байгаа юм байна.

Харин пестицид хэрэглэхгүй байгаагийн шалтгааныг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй нэгжийн (7) 60% нь хэрэглэх шаардлагагүй, 20% нь хөнөөлт организмын асуудал гараагүй, мөн пестицид олддогүй улмаас гэж хариулсан байна /Зураг 18/.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Монгол улсын газар тариалангийн үйлдвэрлэл хөнөөлт организмын хөнөөлтэй холбоотой асуудал ихсэж байгаа, үүнтэй холбоотойгоор химийн пестицидийн хэрэглээ жил ирэх тусам өсөх хандлагатай байгааг харуулж байна.

6. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС, БОРДООНЫ ОЛДОЦ, ХУДАЛДАН АВАЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

Монгол улсад худалдаалагдаж байгаа пестицидийн ихэнх хувийг ТЭДС нийлүүлж байгаа бөгөөд буудай тариалдаг тариаланчдад ихэвчлэн гербицидийг /Раундап/ зээлээр олгож байна. Үүнээс гадна “Гацуурт” ХХК нь пестицидийг өөрөө импортлогч, пестицид хариуцсан мэргэжилтэнтэй, өөрийн хэрэгцээнээс гадна бусад аж ахуй нэгжүүдээ борлуулдаг байна. “Шим” ХХК нь ихэвчлэн инсектицид, фунгицид, гербицидийг бөөнөөр болон жижиглэнгээр борлуулж байна.

Фунгицид, инсектицидийн жижиглэнгийн худалдаачид голдуу Хоршоологчдын холбооны байранд байрлах дэлгүүр, хувь хүмүүс байна. Эдгээр нь пестицидийг зориулалтын бус саванд хийж зардаг аюултай нөхцөл байдлыг бий болгож байгаа нь энэхүү судалгаагаар харагдлаа. Хувь худалдаачид хөнөөлт шавьж ид гарах цагаар талбайгаар явж борлуулалт хийж байна. Иймэрхүү жижиглэнгийн худалдаачид нь пестицидээ хаанаас авдаг талаар харьяалах байгууллага мэдэж зохицуулах шаардлагатай байгаа нь бидний судалгааны явцадхарагдлаа.

Манай тариаланчид бордоог худалдан авах аж ахуй нэгжийг сонгохдоо бордооны төрөл, үнэ өртөг, түүнчлэн тухайн компаны байршлыг харгалзан үздэг байна /Зураг 19/. Тариаланчид бордоо хэрэглэх сонирхолтой байгаа бөгөөд бордооны үнэ өртөг, олдоц чухал байгаа нь харагдаж байна.

Улаан буудайн тариалан эрхлэгчдэд бордоо нийлүүлдэг гол харилцагч нь ТЭДС бөгөөд бордоог зах зээлийн үнээс 30-45% хувиар хямд хөнгөлөлттэй үнээр худалдаалж байна.

7. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС ШҮРШИХ, БОРДОО ЦАЦАХ ТЕХНИКИЙН ХАНГАМЖ

Тариаланчид пестицидийг зориулалтын шүршигч ашиглан шүрших нь ховор байлаа. Талбайн хэмжээнээс хамаарч янз бүрийн овор хэмжээт техникүүд ашиглаж байна. Зарим аж ахуй нэгжүүд бордоо цацах, ариутгах зориулалттай төхөөрөмжүүдийг ургамал хамгааллын бодисыг шүрших зориулалтаар ашиглаж байна. Мөн гар аргаар хийсэн шүршигчийг ашиглаж байна.

Ургамал хамгааллын бодис талбайд цацах зорилгоор аж ахуйн нэгжүүд хуучин ЗХУ-д үйлдвэрлэсэн ОПШ-5, ОБТ-1200 зэрэг шүршигчийг өргөн ашиглаж байна. Харин 2010 оноос хойш Challenger, Spray spy, Summer ultimate, Hardi2007 зэрэг шүршигчдийг ашиглаж байна. Орчин үеийн шүршигч машиныг үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг томоохон аж ахуй нэгжүүд, харин гар шүршигчийг хүнсний ногоо тариалагчид өргөн ашиглаж байна.

Судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдээс пестицид хэрэглэхийн ач холбогдлын талаар судалгаа явуулахад ургац нэмэгддэг гэсэн хариултыг нийт оролцогсодын 95.2% нь буюу 40 аж ахуйн нэгж өгсөнөөс үзэхэд химийн пестицид нь ургац хамгаалдаг гэдэг итгэл үнэмшилтэй байна. Харин гагцхүү пестицидийг зохистой хэрэглэх талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байдаг нь судалгааны явцад ажиглагдсан.

Ихэнх тариаланчид бордоо цацах тусгай зориулалтын техникгүй бөгөөд түүний оронд үрлэгч, пестицид шүршигчийг ашиглаж байна. Эдгээр техникүүдийг дийлэнх аж ахуй нэгжүүд сүүлийн 1-5 жилд худалдаж авсан байна /Зураг 20/. Энэ нь бордоог сүүлийн жилүүдэд өргөн ашиглах хандлага буй болж буйг харуулж байгаагаас гадна бордоо цацах зориулалтын машины нийлүүлэлт, борлуулалт нэмэгдэх хандлагатайг харуулж байна. ОХУ-д үйлдвэрлэсэн СЗС-2,1 СЗП-3,6 болон Омычка-2,1 маркийн үрлэгч, түүнчлэн ОП-7000 шүршигч, 1РМГ-4 /зориулалтын бордоо цацагч тарилттай хамт/ зэргийг тариаланчид бордоо цацахад өргөн ашиглаж байна. Зарим томоохон аж ахуй нэгжүүд сүүлийн үеийн Challenger Kast, Phleksi-sail, Case IH, New Holland зэрэг зориулалтын машиныг ашиглаж байна.

8. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС БОЛОН БОРДООНЫ СОНГОЛТ

Аж ахуй нэгжүүд өөрийн тариалангийн талбайн хөрсний үржил шим, бордооны үнэ өртөг, олдоцыг харгалзан бордоог сонгож байна /Зураг 21/. Энэ нь манай тариаланчид бордоо хэрэглэх сонирхол байдаг боловч, бордооны үнэ, олдоц хязгаарлагч хүчин зүйл болж байгааг харуулж байна.

Тариаланчид нь пестицид худалдан авахдаа нэгдүгээрт илэрч байгаа хөнөөлт организм (21 аж ахуй 50%), хоёрдугаарт үнэ (17 аж ахуй 40.7%), гуравдугаарт олдоц (13 аж ахуй 30.9%), дөрөвдүгээрт бусад шалтгаануудыг тооцон сонголтыг хийж байна /Зураг 22/. Энэ нь тариаланчид пестицид сонгохдоо бодит мэдлэг, мэдээлэлд тулгуурлан сонгохыг ямар нэгэн хэмжээгээр хичээдэг боловч пестицидийн үнэ болон олдоц шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байгааг илтгэж байна.

Пестицид борлуулагч аж ахуй нэгжүүдийг сонгохдоо нэгдүгээрт тухайн пестицидийн нэр төрөл (13 аж ахуй 30.9%), хоёрдугаарт мэддэг хувь хүн эсвэл аж ахуй нэгж (12 аж ахуй 28.5%), үнэ (12 аж ахуй 28.1%) , гуравдугаарт үнэ (11 аж ахуй 26.1%), дөрөвдүгээрт тухайн аж ахуй нэгжийн байршил (8 аж ахуй 19%)-ийг харгалзан үзэж байна /Зураг 23/.

Тариаланчдын тухайн жилд худалдан авах пестицидийн хэмжээ өөр өөр байдаг тухай судалгаанд оролцогчдын 90% нь хариулсан ба үүний шалтгаан нь илэрч байгаа хөнөөлт организмын төрөл, санхүүгийн боломжоос хамаардаг байна /Зураг 24/.

Монгол улс дахь пестицидийн олдоцын талаарх асуултанд 20 аж ахуй буюу 47.6% нь хангалтгүй, 18 аж ахуй буюу 42.8% нь боломжийн, 4 аж ахуй буюу 9.5 % нь сайн гэж хариулсан байна /Зураг 25/.

Судалгаанд оролцсон нийт тариаланчид Монгол улсад зарагдаж байгаа бүх төрлийн пестицидүүдийн чанар маш муу гэж байна гэж ярьж байсныг зориуд тэмдэглэж байна. Энэ нь маш олон шалтгаантай байж болох бөгөөд үүнийг мэргэжлийн лаборатор, талбайн туршилтуудаар дахин нягталж үзэх шаардлагатай юм.

Судлаачид, ургамал хамгаалах бодисыг импортлогч аж ахуй нэгжүүд олон улсын чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн төдийлөн оруулж ирэхгүй байна гэж дүгнэжээ. Энэ нь эргээд хөнөөлт организмуудыг тэсвэртэй болгох, хөнөөлт организмыг устгахын тулд эргээд тунг ихэсгэн хэрэглэх эсвэл өөр төрлийн бэлдмэлүүдтэй дур мэдэн хольж хэрэглэх эрсдлийг үүсгэж, үүнээс улбаалан пестицидийн үлдэгдэл бүхий бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх аюултай сөрөг үр дагаврыг бий болгож байна.

9. ДҮГНЭЛТ БА ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТ:

1. Ихэнх аж ахуй нэгжүүд хөрсний шинжилгээ өгөх үүрэгтэй гэж хандаж байгаа бөгөөд шинжилгээний үр дүнг харгалзан эрдэс бордоог огт хэрэглэддэггүй байна.
2. Манай орон шиг ургамал ургалтын хугацаа богино улс орны хувьд нийлмэл ба бусад бордоог 8 сард хэрэглэсэн тохиолдолд буудайн болцыг сунжруулж, хураалтанд сөрөг нөлөөтэй байна.
3. ТЭДС-аас тариаланчдад бордоо, гербицидийг хөнгөлөлттэй өгөх нэрийдлээр үнэ, хэрэгцээний хөөрөгдлийг үүсгэж байна. Энэ зарчим зөвхөн тодорхой хэдэн аж ахуй нэгжид үйлчилдэг.
4. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид бордоо хэрэглэх шаардлагатайг ойлгож байгаа ч бордооны үнэ хэт өндөр, мөн олдоц тааруу байгаагаас тогтмол хэрэглэх боломжгүй байна.
5. Ихэнх тариаланчид зориулалтын бордоо цацах техникгүй бөгөөд үрлэгч, пестицид шүршигчийг ашиглаж байгаа нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөс гадна зориулалтын машин ашиглах боломжийг нэмэгдүүлэх талаар анхаарах цаг болсныг гэрчилж байна.
6. Аж ахуй нэгжүүдийн тариалангийн талбайн хөрсийг шинжлүүлдэг боловч хөрсний шинжилгээг ямар байгууллагаар, ямар давтамжтайгаар, ямар үзүүлэлтээр хийлгэхээ мэддэггүй, хөрсөө шинжилгээний үр дүнд үндэслэн бордоо хэрэглэдэг шаардлагатай гэдгийг ойлгодоггүй нь энэ талаар мэдээлэл, мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

7. Нийт аж ахуй нэгжүүдийн хувьд хөрсний шинжилгээгээр азот, кали, фосфор үндсэн элементүүдээс гадна хөрсний рН, ялзмагийн агууламж зэргийг үзүүлдэг нийтлэг жишиг тогтсон байна.
8. Тариаланчид, хөрсний үржил шимийг хамгаалах талаар өөрийн бүс нутагт тохирох арга технологийг мэдэхгүй байна.
9. Хүнсний ногоо тариалагчид нэр хаяг нь тодорхойгүй өсөлт идэвхижүүлэгчдийг аман мэдээлэлээр замбараагүй хэрэглэж байгааг анхаарах хэрэгтэй. Гумат гэж нэр, хаяг нь тодорхойгүй бэлдмэлийг хэрэглээд бүх ургамал нь үхсэн тохиолдол гарсаныг аль аль төвшинд онцгой анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.
10. Нэг төрлийн химийн пестицидийг хэт удаан хугацаанд байнга хэрэглэж байгаа учраас хөнөөлт шавьж, зарим хог ургамал үхэхээ больсон. Тухайлбал: Децис, Карате, Гезагард гэх мэт.
11. Сүүлийн үед борлуулагдаж байгаа инсектицидүүдийн чанар муудсан, хөнөөлт шавьжууд үхэхгүй байгаагаас керолинтэй хольж ногоочид их хэрэглэж байгаа.
12. Рапсын талбайд тохирох гербицид Монгол улсад нийлүүлэгдэхгүй байна.
13. Пестицидийн жижиглэнгийн борлуулагчид зориулалтын бүс саванд (ус, Coca cola) инсектицид, фунгицидийг савлан зарж байна.
14. Пестицидийг хор гэдэг талаас нь ойлгохгүй хэрэглэж байгаа тариаланчид их байна.
15. Пестицидийн аюулгүй, зохистой хэрэглэх талаар ихэнх тариаланчид мэдлэггүй байна.
16. Пестицидтэй ажиллагсад зориулалтын тоног төхөөрөмж, хувцас гэх мэтийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангагдахгүй байна.
17. Пестицидийн тунг тохируулах, ажлын уусмалыг бэлтгэх, хэрэглэх сүүлчийн хугацааны талаар мэдлэггүй байна.
18. Судалгаанд оролцсон нийт тариаланчид Монгол улсад зарагдаж байгаа бүх төрлийн пестицидүүдийн чанар маш муу байна гэснийг зориуд тэмдэглэж байна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Нэг. Тариаланчдад хүргэх зөвлөмж:

1. Улаан буудайн тариалалт эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн хувьд сэлгээнд буурцагт ургамлыг оруулан тариалж, органик азотын хуримтлалыг бий болгох нь бордоо байдлаар азотыг өгсөнөөс илүү үр нөлөөтэй байх боломжтойг ашиглах;
2. Хөрсний үржил шимийг сайжруулах нөлөө бүхий сэлгээний таримлыг бүс нутгийн онцлогт тохируулан сонгон хэрэглэх;
3. Хөрсний бүтцэд сөрөг нөлөө багатай хөрс боловсруулах, тариалах технологийг тухайн бүс нутгийн хөрсний хэв шинж, цаг агаарын онцлогт тохируулан мэдлэгтэйгээр ашиглах;
4. Бордоог үндсэн болон нэмэлт хэлбэрээр хэрэглэж болох ч ялангуяа нэмэлтээр өгч байгаа тохиолдолд таримлын болц гүйцэхэд сөргөөр нөлөөлөх эрсдлийг тооцож хэрэглэх;

5. Хөрсний шинжилгээгээр үндсэн элементүүд (N;P;K)-ээс гадна бусад бичил элементүүдийг нарийвчлан шинжлүүлэх, үр дүнг нь бордооны хэрэглээтэйгээ холбох;
6. Бордооны тунг хөрсөнд байгаа уг элементүүдийн хангамжинд тохируулан хэрэглэх;
7. Пестицидийг Монгол улсад өвөлжүүлээд хэрэглэхэд ямар ч үйлчлэлгүй болж байгаа тул импортолсон улиралдаа хэрэглэх эсвэл хадгалах нөхцлийг бэлтгэсний дараа нөөцлөх байдлаар хэрэглэх;

Хоёр. ХХААХҮЯ, Мэргэжлийн хяналтын холбогдох төр, захиргааны байгууллагад:

8. Импортоор орж ирж буй бордооны чанар, хэмжээний хяналтыг сайжруулах арга хэмжээ авах;
9. Бордооны үнэ, ханшны тогтвортой байдлыг хангах, бордооны төрөл, олдоцыг сонголттой байхад төрөөс анхаарах, зохицуулалт хийх;
10. Ургамал хамгаалал, ургамлын хорио цээртэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааг идэвхижүүлэх, гадаад болон дотоод хорио цээртэй хөнөөлт организмын тархан суурьшилтын талаар бодитой үнэн зөв мэдээлэл гаргахыг шаардах;
11. Пестицид импортлогч аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, чанартай бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх зохицуулалтыг хийх;
12. Пестицид импортлох, түгээх, хэрэглэх хууль, журмыг боловсронгуй болгож, мөрдүүлэх;
13. Пестицид худалдаалагч аж ахуй нэгжүүдийг борлуулсан пестицидийн сав, баглаа боодлыг эргүүлэн татаж устгадаг журмын зохицуулалтыг гаргаж, хэвшүүлэх, төрөөс хяналт тавих;


Гурав. Эрдэм шинжилгээ, сургалт, нэвтрүүлэлтийн байгууллагад:

14. Хөрсний үржил, шим, хөрс хамгаалах технологи ба бордооны зохистой хэрэглээтэй холбоотой сургалт /захирал, менежер, агрономч нарт/-ыг тогтмол зохион байгуулах.
15. Хөнөөлт организмыг таних, тодорхойлох энгийн арга техникийг тариаланчдад сургах, хөнөөлт организмын гаралт тархалтаас урьдчилан сэргийлэх арга технологийг тэдэнд зөвлөх арга хэмжээг зохион байгуулах;
16. Хөнөөлт организмтой тэмцэх арга технологийг агротехнологитой холбож судлах, хөнөөлт организмтой химийн бус аргаар тэмцэх өөр хувилбаруудыг дадал болгох;
17. Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицож чадах тэмцэх аргын технологийг бүс нутгийн онцлогт тохируулан боловсруулж хэрэглэгчдэд санал болгох;
18. Пестицидийн талаарх ерөнхий мэдлэгийг импортлогч, жижиглэнгийн түгээгчид, тариаланчдад хүргэж, үйлчилгээ, аюулгүй ажиллагааг ойлгуулах;
19. Пестицидийн аюулгүй, зохистой хэрэглээний талаар талбайн сургалт байнга явуулах.
20. Нэг төрлийн пестицидийг дагнан удаан хэрэглэх, түүнээс үүсэх сөрөг үр дагаврыг тодорхой болгох судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;


21. Судалгаа, шинжилгээний байгууллагуудаас таримал бүрээр түлхүүр гоц хөнөөлт организмыг тодорхойлж, тэмцэх аргын оновчтой технологи гаргаж үйлдвэрлэлд зөвлөхийг хөхүүлэн дэмжих

ХАВСРАЛТ


ХАВСРАЛТ 1



5.Хөрсний дээж авах талаар та сургалтанд сууж, мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч байсан уу.




7.Та хөрсний үржил шим, түүнийг хамгаалах талаар ямар ойлголттой байдаг вэ




8.2016 оны бордооны хэрэглээ


■ бордоо авсан ■ бордоо аваагүй









6.Хэрэв тийм бол ямар үзүүлэлтүүдийг хөрсөндөө үзүүлдэг вэ




9. Та жил бүр ижил хэмжээгээр бордоо худалдан авдаг уу, эсвэл тухайн жилээс хамаарч өөр өөр хэмжээгээр авдаг уу









19. Бордоо худалдаж авах шийдвэр гаргахдаа анхаардаг зүйлс




20. БОРДОО ЦАЦАГЧИЙН АШИГЛАЛТ




21. Та бордоо худалдаж авахдаа юуг анхаардаг вэ, шалтгааныг эрэмбэлвэл



22. Тариаланчид нь пестицид худалдан авахдаа анхаардаг зүйлс





23. Пестицид борлуулагч аж ахуй нэгжүүдийг сонгохдоо анхаардаг зүйлс



24 Пестицидийн худалдан авах хэмжээ

■ жил бүр ижил хэмжээгээр авдаг ■ жил бүр өөр өөр хэмжээгээр авдаг





ХАВСРАЛТ 2

САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС (А)

БОРДОО

А. АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1. Аж ахуйн нэгжийн нэр, байршил:

.....

.....

2. Танай аж ахуйн нэгж газар тариалангийн үйлдвэрлэлийг хэдэн жил эрхэлж байна вэ?

5хүртэлх жил 5-10 жил 10-аас дээш жил 15-аас дээш жил

☐ ☐ ☐ ☐

3. Танай нийт эргэлтийн талбайн хэмжээ хэд вэ?

5-10 га ☐ 50-100 га ☐ 1000-5000 га ☐

10-50 га ☐ 100-1000 га ☐ 5000-20 000 га ☐

4. Танай компани, аж ахуйн нэгж усалгаатай тариалан эрхэлдэг үү? Хэрэв тийм бол ямар төрлийн усалгааны систем ашигладаг вэ? (түхайлбал: дүслын усалгаа, бороожуулагч гэх мэт...)?

.....

.....

.....

5. Танай компани, аж ахуйн тарьдаг таримал?

№	Таримлын нэр	Тариалдаг талбай (га)	Үүнээс усалгаатай талбай (га)	Дундаж ургац га-гаас
1	Хүнсний ногоо			
2	Төмс			
2	Үр тарианы ургамал			
3	Тосны ургамал			
4	Жимс, жимсгэнэ			
5	Тэжээлийн таримал			
6	Бусад таримал			
Нийт талбай				

6. Тариалангийн талбайдаа сэлгээ мөрддөг үү?

тийм ☐ Үгүй ☐

Хэрэв тийм бол сэлгээнийхээ хэвшилүүдийг бичнэ үү?

.....

.....

Б. БОРДООНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР

7. Танай компани, аж ахуйн нэгж хөрсөндөө бордоо хэрэглэдэг үү?

Тийм, тогтмол ☐ хааяа ☐ Огт хэрэглэдэггүй ☐

8. Хэрэв тийм бол, хэдэн жил бордоо хэрэглэж байна вэ?

1-5 жил ☐ 5-10 жил ☐ 10-аас дээш жил ☐

9. Хэрэв бордоо хэрэглэдэггүй бол, ямар шалтгаантай хэрэглэдэггүй вэ? (Энд хамгийн чухал гэсэн 3 шалтгааныг 1-6 хооронд эрэмбэлнэ үү!)

Олдоц муу ☐ үнэ хэт өндөр ☐ Бордоо хэрэглэх шаардлаггүй гэж үздэг ☐

Хэрэглэж мэдэхгүй ☐ Хөрсний үржил шим хангалттай сайн ☐ Бусад шалтгаан ☐

10. Танай компани, аж ахуйн нэгж ямар маркын техник, тоног төхөөрөмжийг ашиглан бордоог хэрэглэдэг вэ? Үйлдвэрлэгчийн нэрийг нь бичнэ үү?

.....
.....

11. Энэхүү техникийг хэр удаан ашиглаж байна вэ?

5хүртэлх жил ☐ 5-10 жил ☐ 10-аас дээш жил ☐ 15-аас дээш жил ☐

12. Ямар төрлийн бордоог ямар таримлын талбайд, ямар хэмжээгээр хэрэглэдэг вэ?

Органик бордоо:

№	Таримлын нэр	Тийм (+) Үгүй (-)	Хэрэв тийм бол, ойролцоогор хэмжээ (тонн / га)	Органик бордооны мэдээлэл ¹
1	Хүнсний ногоо			
2	Төмс			
3	Үр тариа			
4	Тосны ургамал			
5	Жимс, жимсгэнэ			
6	Тэжээлийн таримал			
7	Бусад таримал			

¹ Компост, сангас, бусад органик бордоо

Эрдэс бордоо:

№	Таримлын нэр	Тийм (+) Үгүй (-)	Хэрэв тийм бол, хэмжээ (тонн / га)	Эрдэс бордооны мэдээлэл ²
1	Хүнсний ногоо			
2	Төмс			
3	Үр тариа			
4	Тосны ургамал			

5	Жимс, жимсгэнэ			
6	Тэжээлийн таримал			
7	Бусад таримал			

13. Танай компани, аж ахуй талбайдаа бордоо хэрэглэдэг хугацаа?

Тариалалтын үед ☐ Ургалтын хугацаанд ☐
 аль аль хугацаанд ☐ огт хэрэглэдэггүй ☐

14. Манай орны хөрсний үржил шимийн хангамж бордоо хэрэглэхгүйгээр хангалттай ургац авах боломжтой юу?

Тийм ☐ Үгүй ☐ Сайн мэдэхгүй байна ☐

² NPK (холимог бордоо 13/13/21) эсвэл NP (20/20), шингэн, үрлэн, нунтаг

15. Бордооны хэрэглээний талаархи ойлголтыг ямар байгууллага, эх үүсвэрээс авдаг вэ?

Ном гарын авлагаас ☐ Өмнөх туршлагатай хүнээс ☐

ХААИС/ Хүрээлэнгээс ☐ Огт авдаггүй ☐

В. ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

16. Танай компани, аж ахуйн нэгжийн тариалангийн талбайн хөрсний хэв шинжийг та мэдэх үү?

мэднэ ☐ мэдэхгүй ☐

Хөрсний хэв шинж:

17. Танай компани, аж ахуйн нэгжийн тариалангийн талбайн хөрсний шим тэжээлт бодисын хангамжийг Та юу гэж дүгнэх вэ?

сайн ☐ дунд зэрэг ☐ муу ☐ мэдэхгүй ☐

18. Танай компани, аж ахуйн нэгжийн тариалангийн талбайн хөрс тариаланд хэр тохиромжтой гэж бодож байна вэ?

тохиромжтой ☐ дунд зэрэг ☐ тохиромжгүй ☐

19. Хөрсний шинжилгээг хэдэн жилийн дамтамжтай хийлгэдэг вэ?

Жил бүр ☐ 3 жил тутамд ☐ 5-10 жилд ☐ Огт хийлгэдэггүй ☐

20. Хөрсний чанарын шинжилгээ хийлгэдэг бол ямар байгууллагаар хийлгэдэг вэ?

ХААИС ☐ Дарханы УГТХ ☐ Бусад ☐

.....

21. Хөрсний дээжсийг авахдаа хэнээр хийлгэдэг вэ?

Манай ажилтан ☐ Гадны мэргэжилтэн ☐

Хөрсний дээж авдаг мэргэжилтний мэргэжил, албан тушаал

.....

22. Хөрсний дээж хэрхэн авах талаар Та сургалтанд сүүж, мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч байсан үү?

Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв тийм бол ямар байгууллагаас зохион байгуулагдсан сургалт семинарт хамрагдаж, ямар мэргэжилтэнгээс зөвлөгөө авч байсан бэ?

.....

23. Бордоо хэрэглэхийх өмнө хөрсөө шинжилгээнд өгдөг үү?

Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв тийм бол, ямар үзүүлэлтүүдээр Та хөрсөө шинжлүүлдэг вэ

N ☐ P ☐ K ☐ микро элемент ☐

ph-үзүүлэлт ☐ ялзмагийн хэмжээ ☐ бусад ☐

24. Та хөрсний үржил шим, түүнийг хамгаалах талаар ямар ойлголттой байдаг вэ ?

Маш сайн

☐

Дунд

☐

Бага зэрэг

☐

Г. БОРДОО ХУДАЛДАН АВАХ ТАЛААР

25. Та бордоогоо хаанаас худалдаж авдаг вэ, худалдан авдаг аж ахуйн нэгжээ бичнэ үү ?

.....

.....

26. Та өнгөрсөн жил хэдий хэмжээний бордоо, хэдэн төгрөгөөр худалдаж авсан бэ?

№	Бордоо	Хэмжээ (тонн)	савласан /задгай	Үнэ /тонн
1				
2				
3				
4				
5				

27. Та бордоо худалдаж авахдаа юүг анхаардаг вэ? (Энд хамгийн чухал гэсэн шалтгаануудыг 1-4 хооронд эрэмбэлнэ үү!)

Олдоц

☐

Үнэ

☐

Хөрсний шим
тэжээлийн хангамж

☐

Тухайн жилийн тариалалын улиралд учирч болох эрсдлийн тооцоолсоны үндсэн дээр

☐

28. Ямар компаниас бордоо худалдаж авах талаар шийдвэр гаргахдаа юүг нь голлон анхаардаг вэ ? (Энд хамгийн чухал гэсэн шалтгаануудыг 1-4 хооронд эрэмбэлнэ үү!)

Бордооны төрөл

☐

Үнэ

☐

Тухайн компанийн
байршил

☐

Мэддэг газраасаа
авдаг

☐

Өөрөө

☐

оруулж ирдэг

Бусад шалтгаан

.....

29. Та жил бүр ижил хэмжээгээр бордоо худалдан авдаг үү, эсвэл тухайн жилээс хамаарч өөр өөр хэмжээгээр авдаг үү ?

жил бүр ижил
хэмжээгээр авдаг

☐

Жил бүр өөр өөр
хэмжээгээр авдаг

☐

Шалтгаан

ХАВСРАЛТ 2

САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС (Б)

ПЕСТИЦИД

А) АНН-ИЙН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН АСУУДЛААР

1. Таны таримлын талбайд ургамал хамгааллын ямар асуудлууд тулгарч байна вэ? (Тохирох хэсгийг дугуйлна уу!)

№	Таримлын төрөл	Хортон шавьжид нэрвэгдэх	Мөөгөн-цөр бактери	Хог ургамал	Оготно, хулгана, зурам	Бусад
1	Хүнсний ногоо					
2	Төмс					
2	Үр тариа					
3	Тосны ургамал					
4	Жимс, жимсгэнэ					
5	Тосны ургамал					
6	Бусад					

2. Таримлын талбайд тулгарч байгаа ургамал хамгааллын асуудлуудыг (ургамлын өвчлөлт, хортон шавьж, хог ургамал гэх мэт) Та бүхэн өөрсдөө тодорхойлдог үү?

Тийм, ☐ Хааяа ☐ Үгүй ☐ Мэргэжилтэнгээс ☐
тогтмол асуудаг

3. Танай талбайд ургамал хамгааллын ямар асуудлууд хамгийн түгээмэл тулгарч байна вэ, нэрлэнэ үү?

Ургамлын өвчлөлт:

.....

.....

Хортон шавьж:

.....

.....

.....

Хог ургамал:

.....

.....

.....

4. Ургамал хамгааллын асуудал тулгархад Та ямар байгууллагад хандаж зөвлөгөө авдаг вэ?

Ургамал хамгааллын хүрээлэн ☐ ХААИС ☐ Пестицидийн борлуулагчаас ☐
Хувь хүнээс ☐ Бусад ☐ Зөвлөгөө авах шаардлаггүй ☐

5. Пестицидийн зүй зохистой хэрэглээний талаар Та сургалтанд хамрагдаж байсан үү?

Тийм, олон удаа ☐ хааяа ☐ Үгүй, огт хамрагдаж байгаагүй ☐

6. Хэрэв тийм бол, Та хамгийн сүүлд ямар сургалтанд хамрагдсан бэ?

Сургалтанд хамрагдсан он сараа бичнэ үү:.....

7. Өнжүүлсэн талбайн хог ургамалтай хэрхэн тэмцдэг вэ?

Химийн уринш хийдэг ☐ механик аргаар хөрс боловсруулах байдлаар ☐

Б) ПЕСТИЦИДИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДЛААР

8. Та талбай дээрээ пестицид хэр их хэрэглэдэг вэ?

№	Пестицид	Тогтмол	Хааяа	Огт хэрэглэж байгаагүй
1	Инсектицид			
2	Фунгицид			
2	Родентицид			
3	Гербицид			
4	Бусад			

9. Танай аж ахуйн нэгж пестицид хэрэглэдэг бол, нийт хэдэн жил хэрэглэж байна вэ?

1-5 жил ☐ 5-10 жил ☐ 10-аас дээш жил ☐

10. Хэрэв пестицид хэрэглэдэггүй бол ямар шалтгаанаар хэрэглэдэггүй вэ?

Шаардлагатай пестицид олдоггүй ☐
Үнэ өндөр ☐
Хэрэглэх шаардлаггүй гэж үздэг ☐
Хэрэглэж байгаагүй учир туршлаггүй ☐
Хэрэглэх шаардлаггүй ургамал хамгааллын асуудал гараагүй ☐

Бусад шалтгаан:.....

11. Пестицидийн хэрэглэх түн хэмжээ, хэрэглэх аргын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?

Борлуулагчаас ☐ пестицидийн шошгон дээрх мэдээллийн дагуу ☐ Сургалт, семинар ☐

Бусад туршлагатай Аж ахуй нэгжээс ☐ гарын авлага, зөвлөмж ☐ Өөрөө тааж хэрэглэдэг ☐

Бусад:

12. Ямар төрлийн пестицидийг ямар таримлын талбайд, хэдэн удаа хэрэглэдэг вэ?

Таримлын төрөл	Пестицидийн нэр	Хэдэн удаа ¹
Хүнсний ногоо		
Төмс		

Үр тариа		
Тосны ургамал		
Тэжээлийн ургамал		
Бусад		

¹ Жилд хэдэн удаа тухайн пестицидийг шүршдэг вэ

13. Танай компани, аж ахуй талбайдаа пестицид хэрэглэдэг хугацаа?

Тариалалтын өмнө ☐ Ургалтын хугацаанд ☐
Тариалалтын үед ☐ өнжөөж байгаа үед ☐

14. Пестицидээ ямар тоног төхөөрөмж ашиглан хэрэглэдэг вэ?

Бордоо цацагч ☐ Гар зориулалтын ☐ онгоцоор ☐
Шүршигч
Ариутгагчаар ☐ Бусад ☐
.....

15. Хор цацагчийнхаа үйлдвэрлэгдсэн он, нэр, марк, загварыг бичнэ үү?

.....
.....
.....

16. Пестицид хэрэглэснээс ургац нэмэгдэх боломжтой гэж бодож байна үү?

Тийм ☐ Үгүй ☐ Мэдэхгүй ☐

В) ПЕСТИЦИД ХУДАЛДАН АВАХ ТАЛААР

17. Та пестицид хаанаас худалдаж авдаг вэ, худалдан авдаг аж ахуйн нэгжээ бичнэ үү?

.....
.....

18. Та пестицид худалдаж авахдаа юүг анхаардаг вэ? (Энд хамгийн чухал гэсэн шалтгаануудыг 1-4 хооронд эрэмбэлнэ үү!)

Олдоц ☐ Үнэ ☐ Ямар төрлийн хортон ☐
шавьж, хог ургамал,
өвчинтөй тэмцэхээс
хамаардаг

Бусад шалтгаан ☐

.....

19. Ямар компаниас пестицид худалдаж авах талаар шийдвэр гаргахдаа юүг нь голлон анхаардаг вэ ? (Энд хамгийн чухал гэсэн шалтгаануудыг 1-4 хооронд эрэмбэлнэ үү!)

Пестицидийн нэр ☐ Үнэ ☐ Тухайн компанийн ☐
төрөл
Мэддэг газраасаа ☐ Бусад шалтгаан
авдаг

.....

20. Та жил бүр ижил хэмжээгээр пестицид худалдан авдаг үү, эсвэл тухайн жилээс хамаарч өөр өөр хэмжээгээр авдаг үү ?

жил бүр ижил
хэмжээгээр авдаг ☐

жил бүр өөр өөр
хэмжээгээр авдаг ☐

Шалтгаан

21. Таны бодлоор Монгол улсад пестицидийн олдоц хэр байгаа вэ?

сайн ☐ боломжийн ☐ хангалтгүй ☐

ХАВСРАЛТ 3

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,
Хүнс, хөдөө аж ахуйн сайд,
Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 дугаар сарын 29 - ны өдрийн
А/51/А-28/57 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД 2016 ОНД ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАЖ БОЛОХ

ХИМИЙН БОРДООНЫ ЖАГСААЛТ, ХЭРЭГЛЭХ ХЭМЖЭЭ

Д/д	Худалдааны нэр	Үйлчлэх бодисын нэр, агуулалт	Томъёо	Хэрэглэх хэмжээ, мян. тн	Зориулалт
1	Шивтрийн шүү /Аммиачная селитра/	Азот (N) 34-35%	NH_4NO_3	140.0	Таримлын төрлөөс хамааран бордоонуудыг хамтад нь хөрс боловсруулалт ба тарилтын үед зөвлөсөн тунгаар хэрэглэх
2	Фосфорын бордоо /Двойной суперфосфат/	Фосфорын исэл (P_2O_5) 42-46%	$\text{Ca}(\text{H}_2\text{PO}_4)_2$	80.0	
3	Калийн бордоо /Хлорт кали/	Калийн исэл (K_2O), 60-62%	KCl	50.0	
4	Мочевин /Urea/	Азот (N) 45-46%	$\text{CO}(\text{NH}_2)_2$	35.0	Үндсэн ба тарилтын болон ургалтын үеийн бордоо
5	Аммонийн фосфат /DAP- Diammonium Phosphate/	Азот (N) 18-21 %; Фосфорын исэл (P_2O_5) 46-53 %	$(\text{NH}_4)_2\text{PO}_4$	50.0	Үндсэн ба тарилтын үеийн бордоо

6	Моно аммонийн фосфат /MAP-Mono ammonium Phosphate/	Азот (N) 11-18%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 48-55%	NH ₄ H ₂ PO ₄	50.0	Үндсэн ба тарилтын үеийн бордоо
7	Нийлмэл бордоо (26-18-0) /Complex fertilizer/	Азот (N) 26%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 18%	N; P ₂ O ₅	50.0	Үндсэн, тарилтын ба ургалтын үед хэрэглэнэ.
8	Нийлмэл бордоо (20-15-10) /Complex fertilizer/	Азот (N) 20%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 15%; Калийн исэл (K ₂ O) 10%	N; P ₂ O ₅ ; K ₂ O	50.0	Үндсэн ба тарилтын үеийн бордоо
9	Нийлмэл бордоо (24-11-10) /Complex fertilizer/	Азот (N) 24%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 11%; Калийн исэл (K ₂ O) 10%	N; P ₂ O ₅ ; K ₂ O	50.0	Үндсэн, тарилтын ба ургалтын үед хэрэглэнэ.
10	Нийлмэл бордоо (18-7-5) /Complex fertilizer/	Азот (N) 18%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 7%; Калийн исэл (K ₂ O) 5%	N; P ₂ O ₅ ; K ₂ O	50.0	Үндсэн ба тарилтын үеийн бордоо
11	Интермаг бордоо	NPK+ микро элемент	N; P ₂ O ₅ ; K ₂ O	-	Үр тарианы болон олон наст үет өвслөг ургамлыг бордох зориулалтаар зааврын дагуу хэрэглэнэ.
12	Ультрамаг Бор	Азот (N) 5 %; Бор (B) 15%	N; B	-	Чихрийн манжин, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ бороор дутагдсан үед зааврын дагуу хэрэглэнэ.
13.	Омекс Секүеншел 1	Азот (N) 10%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 40%; Калийн исэл (K ₂ O) 20% Магни; Төмөр; Манган; Зэс; Цайр; Бор; Кобальт; Молибден	N; P ₂ O ₅ ; K ₂ O; MgO; Fe; Mn; Cu; Zn; B; Co; Mo	-	Үр тариа, төмс, хүнсний ногооны таримлын ургалтын эхний үед 1-2 удаа бордоход 2-3 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.

14	Омекс Секүеншел 2	Азот (N) 10%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 20%; Калийн исэл (K ₂ O) 40%; Магни; Төмөр; Манган; Зэс; Цайр; Бор; Кобальт; Молибден	N; P ₂ O ₅ ; K ₂ O; MgO; Fe; Mn; Cu; Zn; B; Co; Mo	-	Үр тариа, төмс, хүнсний ногооны таримлын ургалтын эхний үед 1-2 удаа кали болон бусад макро, микро элементүүд шаардлагатай үед бордоход 2-3 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
15	Омекс K41	Азот (N) 3%; Калийн исэл (K ₂ O) 41%; Магни; Хүхэр	N; K ₂ O; MgO; S	-	Төмс, жимс жимсгэнэ, гуатны төрлийн ургамлын цэцэглэлтээс булцуу, жимс үүсэх үед 2-3 удаа шим тэжээлийн бодисын балансыг алдагдуулалгүйгээр кали болон магни хэрэгцээг хангахад 3-5 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
16	Омекс Фолиар Бор	Азот (N) 6 %; Бор (B) 15%	N; B	-	Хүнсний ногоо, рапс, жимс жимсгэний таримлын ургалтын эхний үед болон цэцэглэлтээс өмнө 2-3 удаа үр жимс үүсэлтийг сайжруулахад, борын дутагдал ажиглагдахад 1-35 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
17	Омекс Калмакс	Азот (N) 15; Кальци (Ca) 22.5; Магни (MgO) 0.15%; Төмөр; Манган; Зэс; Цайр; Бор; Молибден	N; Ca; MgO; Fe-EDTA; Mn-EDTA; Cu-EDTA; Zn-EDTA; B; Co; Mo	-	Төмс, хүнсний ногоо, рапсын талбайн кальцийн агууламжыг нэмэгдүүлэх, жимсийг урт хугацаагаар хадгалах, гадны нөлөөгөөр амархан гэмтэхгүй болгох, усжих, цоохортох, дотроосоо хүрэлтэх зэргээс хамгаалахын тулд 1.5-8.5 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
18	Омекс Куад 14	Азот (N) 14.76%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 14.76%; Калийн исэл (K ₂ O) 14.76%; Кальци (Ca) 14.76	N; P ₂ O ₅ ; K ₂ O; Ca	-	Төмс, навчит ногоо, сонгино, луувангийн тарималд ус дутагдах болон ууршилт ихтэй үед үүсэх кальцийн дутагдлыг нөхөж стрессээс гаргах ба шим тэжээлийг тэнцвэржүүлэхэд 1.5-3 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
19	Омекс DP98	Азот (N) 4%; Фосфорын исэл (P ₂ O ₅) 37.5%; Калийн исэл (K ₂ O) 17.4%;	N; P ₂ O ₅ ; K ₂ O	-	Төмс, хүнсний ногоо, рапсын таримал дотор фосфорын зөөгдөлтийг сайжруулахад 2-4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
20	Омекс микромакс	Магни (MgO) 1.95; Төмөр (Fe) 2.60; Манган; Зэс; Цайр (Zn) 2.60; Бор; Молибден; Хүхэр	MgO, Fe, Mn, Cu, Zn, B, Mo, S	-	Үр тариа, төмс, хүнсний ногоо, буурцагт тарималд микро элементүүд шаардлагатай үед 0.75-1.5 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.

21	PER-4 Max	Азот (N)10-30%, Төмөр (Fe) 5-15%, Магни (Mg) 1-10%, Манган (Mn) 1-5%	N; Fe; Mg; Mn	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 5-10 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
22	ProteSyn	Азот (N) 10-25%; фосфорын исэл (P ₂ O ₅) 1-15%; калийн исэл (K ₂ O) <1%	N; P ₂ O ₅ ; K ₂ O	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 20-25 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
23	PK Fight	Фосфорын исэл (P ₂ O ₅)20-50%;калийн исэл (K ₂ O) 5-25	P ₂ O ₅ ; K ₂ O	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 10-15 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
24	Carbon N	Азот (N) 20-40%;	N	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 5-8 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
25	Planet Turf (11-22-14)	Азот (N) 11%; фосфорын исэл (P ₂ O ₅) 22%; калийн оксид (K ₂ O) 14%; магни (Mg) 1%; хүхэр (S) 5.5%; төмөр (Fe) 1%	N; P ₂ O ₅ ; K ₂ O; Mg; S; Fe	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 20-26 кг/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
26	PT-PRO (26-0-0)	Азот (N) 26%; хүхэр (S) 8%	N; S	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 25-30 кг/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ
27	Planet Turf (24-4-12)	Азот (N) 24%; фосфорын исэл (P ₂ O ₅) 4%; калийн оксид (K ₂ O) 12%; кальци (Ca) 7%;	N; P ₂ O ₅ ; K ₂ O; Ca;	-	Ургамлан нөмрөгийг сайжруулахад 24-32 кг/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ

ХАВСРАЛТ 4

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд,
Хүнс, хөдөө аж ахуйн сайд,
Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 дугаар сарын 29 - ны өдрийн
А/51/А-28/57 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД 2016 ОНД ХӨДӨӨ АЖ АХУЙД УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАЖ БОЛОХ ПЕСТИЦИДИЙН ЖАГСААЛТ, ХЭРЭГЛЭХ ХЭМЖЭЭ

Нэг. 2016 онд хөдөө аж ахуйд ашиглаж болох пестицидийн жагсаалт

Д/д	Худалдааны нэр	Үйлчлэх бодисын нэр, хувь, хэмжээ	Томъёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Зориулалт
ИНСЕКТИЦИД					
1.	Децис	Дельтаметрин 2.5%	$C_{22}H_{19}Br_2NO_3$	52918-63-5	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
2.	Децимон	Дельтаметрин 2.5%	$C_{22}H_{19}Br_2NO_3$	52918-63-5	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
3.	Сумицидин,	Фенвалерат 20%	$C_{25}H_{22}ClNO_3$	51630-58-1	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
4.	Сумипланта	Фенвалерат 20%	$C_{25}H_{22}ClNO_3$	51630-58-1	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.4 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
5.	Каратэ, МКС	Лямбда-цигалотрин	$C_{23}H_{19}ClF_3NO_3$	91465-08-6	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт

		5%			шавьж, хачигийн эсрэг 0.15-0.2 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
6.	Каратэ, ЕС	Лямбда-цигалотрин 5%	$C_{23}H_{19}ClF_3NO_3$	91465-08-6	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьж, хачигийн эсрэг 0.15-0.2 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
7.	Каратокс	Лямбда-цигалотрин 5%	$C_{23}H_{19}ClF_3NO_3$	91465-08-6	Бэлчээр, ой, таримлын болон агуулахын хөнөөлт шавьж, хачигийн эсрэг 0.15-0.2 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
8.	Кинмикс, КЭ	Бета-циперметрин 5%	$C_{22}H_{19}Cl_2NO_3$	65731-84-2	Бэлчээр, таримлын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.5 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
9.	Кинтар	Бета-циперметрин 5%	$C_{22}H_{19}Cl_2NO_3$	65731-84-2	Бэлчээр, таримлын хөнөөлт шавьжийн эсрэг 0.3-0.5 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
10.	Таран, ВЭ	Зэта-циперметрин 10%	$C_{22}H_{19}Cl_2NO_3$	52315-07-8	Бэлчээр, ой, таримлын хөнөөлт шавьжийн эсрэг 0.15-0.2 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
11.	Тарацид	Зэта-циперметрин 10%	$C_{22}H_{19}Cl_2NO_3$	52315-07-8	Бэлчээр, ой, таримлын хөнөөлт шавьжийн эсрэг 0.15-0.2 л/га тунгаар зааврын дагуу хэрэглэнэ.
